ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 09 өдөр Дугаар 20 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн олон улсын эмнэл зүйн удирдамжийн талаарх заалтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нотолгоонд суурилсан эмнэл зүйн удирдамжид суурилсан тусламж үйлчилгээг худалдан авах, чанарын болон төлбөрийн хяналт тавих зорилгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.8.7, 14.9.1, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.2 дахь заалт, 34.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим платформ-оюуны өмчийн эрх бүхий “UpToDate” үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвөөс гэрээ шууд байгуулах аргаар худалдан авахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д заасан даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан хэрэгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай.

3. Гэрээ шууд байгуулах худалдан авалтын аргыг хэрэглэх болсон үндэслэл болон гэрээний хувийг Сангийн яаманд хүргүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Л.Номин/-нд даалгасугай.

ДАРГА Т.МӨНХСАЙХАН

1117149846
ТУЗ0845 Я 5284708